

БАТЛАВ. СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ  Л.ЭРДЭНЭХҮҮ

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НАМРЫН УЛИРЛЫН “ЭРДМИЙН БАЯР”
ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь Монголын үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн эх орондоо сургаж бэлтгэх ажлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны тогтоолоор эхлүүлж 6 аравны түүхийг бүтээж яваа Монголын ууган их сургуулийн нэг билээ.

2023-2024 оны хичээлийн жилд бакалаврын 91, магистрын 53 дах удаагийн “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна.

Арга хэмжээний зорилго:

ШУТИС-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн намрын улиралд төгсөж буй нийт суралцагчдад “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулахад оршино.

Хамрах хүрээ:

ШУТИС-ийн эрдэмтэн багш, ажилтан, нийт төгсөгчид, гэр бүл, найз нөхөд оролцоно.

Хэзээ: 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 10:00-18:00 цагт

Хаана: Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн төв байр 3 давхарт “Хурлын танхим”

Төгсөгчдийн тоо:

- Магистр: 259
- Бакалавр: 772
- Нийт: 1031

Арга хэмжээний зохион байгуулалт:

- “Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд оролцох нийт 875 төгсөгчийг бүрэлдэхүүн сургууль тус бүрээр 4 хэсэгт хуваан гардуулах бөгөөд хэсэг бүрд нийт 200-250 төгсөгч хамрагдахаар зохион байгуулна. Дархан, Эрдэнэт нийт 156 төгсөгчийн дипломыг сургууль тус бүр дээр хуваарийн дагуу гардуулна.
- Төгсөгчдийн баярын үйл ажиллагаанд нийт төгсөгчид, ШУТИС-ийн захирлууд, эрдэмтэн багш нар, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд дараах хуваарийн дагуу оролцоно. Үүнд:

Хүснэгт.1

№	Үйл ажиллагаа	Хамрагдах төгсөгчийн тоо	Огноо	Цаг	Хэсгийн дугаар	Оролцох удирдлагууд
	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	71	2024.01.19	10:00-11:30	I хэсэг	Т.Намнан Н.Эрдэнэхүү А.Энхбат Г.Баттүвшин Ж.Туяацэцэг Салбар, тэнхимийн эрхлэгч нар
	Бизнесийн ахисан түвшний сургууль	75				
	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	74				
Нийт:		220				
2	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	103	2024.01.19	12:00-13:30	II хэсэг	Т.Намнан Н.Эрдэнэхүү Н.Чулуунбанди К.Хавалболот Салбар, тэнхимийн эрхлэгч нар
	Геологи, уул уурхайн сургууль	121				
Нийт		224				
3	Барилга, архитектурын сургууль	155	2024.01.19	14:00-15:30	III хэсэг	Т.Намнан Л.Баяр-Эрдэнэ Б.Нарантуяа Н.Пүрэвдорж Салбар, тэнхимийн эрхлэгч нар
	Механик, тээврийн сургууль	72				
Нийт		227				
4	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	19	2024.01.19	16:00-17:30	IV хэсэг	Т.Намнан Д.Цолмонбаатар Ц.Энхбаатар В.Өлзийбаяр Б.Бат-Эрдэнэ Салбар, тэнхимийн эрхлэгч нар
	Гадаад хэлний сургууль	12				
	Эрчим хүчний сургууль	173				
Нийт		204				
ДаТС		126	2024.01.19	14:00-15:30	Орон нутаг дахь сургуулиуд тусдаа гардуулалт хийгдэнэ.	Тухайн сургуулийн захирал, салбар, тэнхимийн эрхлэгч нар
ЭЦДС		30	2024.01.19	14:00-15:30		

Анхааруулга:

- “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагаанд оролцож буй нийт төгсөгчид 30 минутын өмнө хүрэлцэн ирж суудлаа эзэлнэ.
- Бүх түвшний төгсөгчид эрдмийн баярын ёслолын өмсгөлөө өмссөн байна.
- Эцэг, эхчүүдийг арга хэмжээ зохион байгуулагдаж буй хурлын танхимд оруулахгүй болохыг анхаарна уу.

**НЭГ: “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

“Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааны заал, тайзыг урьдчилан бэлтгэж ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг хэсэгчлэн зохион байгуулна.

2024.01.19-ний өдрийн 10:00-11:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр

• **I хэсэг (БУХС, БАТС, ҮТС)**

- 09:30-10:00 ШУТИС-ийн төв байр хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх
- 10:00-10:03 Нээлт Хөтлөгч
- 10:03-10:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.
- 10:05-10:15 ШУТИС-ийн Захирал доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.
- 10:15-10:17 Төрийн дуулал эгшиглэнэ.
- 10:17-10:20 Төгсөгчдөд диплом олгох Захирлын тушаалыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.
- 10:20-10:50 Диплом гардуулах үйл ажиллагаа: Бүрэлдэхүүний сургуулийн танилцуулга, төгсөгчдийн дурсамж бичлэг. Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (Төгсөгчдийн нэрсийг дуудаж диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна)
- Магистрын зэрэгтэй төгсөгчид
 - Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- 10:50-10:55 Профессорын мэндчилгээ (ҮТС)
- 10:55-11:00 Магистрын зэрэг хүртсэн төгсөгч үг хэлнэ. (БАТС)
- 11:00-11:05 ШУТИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ. (БУХС)
- 11:05-11:10 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол
- 11:10-11:15 Малгай шидэлтийн баяр
- 11:15-11:20 Ёслолын ажиллагааны хаалт
- 11:20-11:30 Заал чөлөөлөх /Заагдсан дурсгалын зураг татуулах хэсэг рүү явах/ 2-р хэсэг суудлаа эзлэх, сургалтын албаны ажилтнууд ромбо, диплом байрлуулах

2024.01.19-ний өдрийн 12:00-13:25 цагийн арга хэмжээний хөтөлбөр

II хэсэг (МХТС, ГУУС)

- 11:30-12:00 ШУТИС-ийн төв байр хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх
- 12:00-12:03 Нээлт Хөтлөгч
- 12:03-12:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.
- 12:05-12:15 ШУТИС-ийн Захирал доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.
- 12:15-12:17 Төрийн дуулал эгшиглэнэ.
- 12:17-12:20 Төгсөгчдөд диплом олгох Захирлын тушаалыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.
- 12:20-12:50 Диплом гардуулах үйл ажиллагаа: Бүрэлдэхүүний сургуулийн танилцуулга, төгсөгчдийн дурсамж бичлэг. Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (Төгсөгчдийн нэрсийг дуудаж диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна)
- Магистрын зэрэгтэй төгсөгчид
 - Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- 12:50-12:55 Профессорын мэндчилгээ (ГУУС)
- 12:55-13:00 ШУТИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ. (МХТС)
- 13:00-13:05 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол
- 13:05-13:10 Малгай шидэлтийн баяр
- 13:10-13:15 Ёслолын ажиллагааны хаалт
- 13:15-13:25 Заал чөлөөлөх /Заагдсан дурсгалын зураг татуулах хэсэг рүү явах/ 3-р хэсэг суудлаа эзлэх, сургалтын албаны ажилтнууд ромбо, диплом байрлуулах

2024.01.19-ний өдрийн 14:00-15:25 цагийн арга хэмжээний хөтөлбөр

III хэсэг (БАС, MeXTC)

- 13:30-14:00 ШУТИС-ийн төв байр хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх
- 14:00-14:03 Нээлт Хөтлөгч
- 14:03-14:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.
- 14:05-14:15 ШУТИС-ийн Захирал доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.
- 14:15-14:17 Төрийн дуулал эгшиглэнэ.
- 14:17-14:20 Төгсөгчдөд диплом олгох Захирлын тушаалыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.
- 14:20-14:50 Диплом гардуулах үйл ажиллагаа: Бүрэлдэхүүний сургуулийн танилцуулга, төгсөгчдийн дурсамж бичлэг. Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (Төгсөгчдийн нэрсийг дуудаж диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна)
- Магистрын зэрэгтэй төгсөгчид
 - Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- 14:50-14:55 Профессорын мэндчилгээ. (БАС)
- 14:55-15:00 ШУТИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ. (MeXTC)
- 15:00-15:05 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол
- 15:05-15:10 Малгай шидэлтийн баяр
- 15:10-15:15 Ёслолын ажиллагааны хаалт
- 15:15-15:25 Заал чөлөөлөх /Заагдсан дурсгалын зураг татуулах хэсэг рүү явах/ 4-р хэсэг суудлаа эзлэх, сургалтын албаны ажилтнууд ромбо, диплом байрлуулах

2024.01.19-ний өдрийн 16:00-17:25 цагийн арга хэмжээний хөтөлбөр

IV хэсэг (ХШУС, ГХС, ЭХС)

- 15:30-16:00 ШУТИС-ийн төв байр хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх
- 16:00-16:03 Нээлт Хөтлөгч
- 16:03-16:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.
- 16:05-16:15 ШУТИС-ийн Захирал доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.
- 16:15-16:17 Төрийн дуулал эгшиглэнэ.
- 16:17-16:20 Төгсөгчдөд диплом олгох Захирлын тушаалыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.
- 16:20-16:50 Диплом гардуулах үйл ажиллагаа: Бүрэлдэхүүний сургуулийн танилцуулга, төгсөгчдийн дурсамж бичлэг. Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (Төгсөгчдийн нэрсийг дуудаж диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна)
- Магистрын зэрэгтэй төгсөгчид
 - Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- 16:50-16:55 Профессорын мэндчилгээ (ХШУС)
- 16:55-17:00 Магистрын мэндчилгээ (ЭХС)
- 17:00-17:05 ШУТИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ. (ЭХС)
- 17:05-17:10 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол
- 17:10-17:15 Малгай шидэлтийн баяр
- 17:15-17:20 Ёслолын ажиллагааны хаалт
- 17:20-17:25 Заал чөлөөлөх /Заагдсан дурсгалын зураг татуулах хэсэг рүү явах/

ХОЁР. “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Бүрэлдэхүүн сургуулийн сургалт, чанарын албуудад өгөх зөвлөмж

- ✓ Бүрэлдэхүүн сургуулиудын сургалт, чанарын алба, төгсөлтийн нарийн бичгийн дарга, оюутны хөгжил, соёл үйлчилгээний алба төгсөлтийн ёслолын ажиллагааг хамтран зохион байгуулна.
- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагаанд дараах дарааллын дагуу нэрсийг дуудаж дипломыг гардуулна. /Магистрын шилдэг, магистр, бакалаврын шилдэг, тэргүүний, бакалавр/
- ✓ Хуваарийн дагуу нэг хэсэгт багтсан бүрэлдэхүүн сургууль тус бүр диплом гардан авах төгсөгчдийн нэрсийг төгсөлтийн арга хэмжээг хөтлөх хөтлөгчид өгч нэрсийг зарлуулан дипломыг гардуулна.
- ✓ Төгсөлтийн хуваарь, дуудах нэрсийн дарааллын дагуу төгсөгчдийн бүх дипломыг бэлтгэн бэлэн болгосон байна.
- ✓ Сургуулийн танилцуулга, төгсөгчдийн гаргасан амжилт, дурсамжуудыг багтаасан 2 минутаас хэтрэхгүй видео шторкийг бэлдэж оюутны хөгжил, соёл, үйлчилгээний алба naamii.nb@must.edu.mn хаягаар 2024 оны 01-р сарын 18-ний дотор ирүүлсэн байна.
- ✓ Хавсралт 2.т заасны дагуу суудал хуваарилалтыг хийж хариуцсан салбар, тэнхимийн багш нарт хүлээлгэн өгч төгсөгчдөд мэдээлэл хүргүүлсэн байна.
- ✓ Үг хэлэх профессор багш, төгсөгчийн бэлтгэл ажлыг хангуулж хөтлөгчид нэрсийг хүргүүлсэн байна.
- ✓ Диплом гардуулах ёслолын ажиллагаанд оролцох салбар, тэнхимийн эрхлэгч нарын нэр, эрдмийн зэрэг цолыг tsogmaad@must.edu.mn хаягаар 2024 оны 01-р сарын 16-ний дотор ирүүлсэн байна.
- ✓ Сургалтын албанаас 2 хүн томилон зохион байгуулалтад оролцуулан төгсөгч оюутнуудыг хурлын зааланд оруулах, арга хэмжээ дуустал заалнаас гаргахгүй эмх цэгцтэй байлгах, хүрэлцэн ирсэн эцэг эхчүүдэд тайлбар зөвлөмж хүргэх.
- ✓ Бүрэлдэхүүн, салбар сургуулийн төгсөгчдийг өөрийн сургуулийн орчинд дурсгалын зураг татуулах боломж бүхий зориулалтын талбайг тохиромжтой байршилд засаж тохижуулах ажлыг хариуцан зохион байгуулна.
- ✓ Хоцорсон, тухайн ээлжид оролцоогүй оюутны дипломыг буцаан авч ёслолын бус цагаар гардуулна.
- ✓ Тусдаа байртай сургуулиуд хавсралт 1.т заасны дагуу 1,2-р байруудад хуваарилагдсан өрөөнүүдэд хувцсаа солино.

Бүрэлдэхүүн сургуулийн төгсөлтийн нарийн бичгийн дарга нарт өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагааны зохион байгуулалтын удирдамжийг салбар, тэнхимийн оюутнуудаа эрдмийн баярт биеэр оролцох эсэх тухай мэдээллийг авч, ирц бүртгэлийг тодорхой болгож сургалтын албанд мэдээлэх.
- ✓ Салбар тэнхимийн оюутнуудыг ёслолын ажиллагааны хуваарийн дагуу цагт нь бүртгэж оруулна.

- ✓ Үг хэлэх сургуулийн төлөөлөл профессор багш, нэр хүндтэй төгсөгчидтэй холбогдож, үйл ажиллагааны хөтөлбөрийг урьдчилан танилцуулж, үгийг бэлдүүлж үйл ажиллагаанд оролцуулна.

Төгсөгчдөд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн өглөөний 10:00 цагаас хуваарийн дагуу зохион байгуулагдана.
- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагаанд нийт төгсөгчид хавсралтад заасан хуваарийн дагуу 4 хэсэгт хуваагдаж диплом гардаж авна.
- ✓ Төгсөлтийн ёслолын арга хэмжээг 1 цаг 30 минутын хугацаанд зохион байгуулагдах бөгөөд дараагийн хэсэг эхлэхээс өмнө 30 минут завсарлана. /Хуваарьт хөтөлбөрийн дагуу/
- ✓ Төгсөгчид хувцас солих, ёслолын арга хэмжээнд оролцох бэлтгэлээ хангах зориулалт бүхий анги танхимын дугаарыг сургалтын албаны мэргэжилтнээс тодруулсан байна.
- ✓ Төгсөгчид хуваарьт цагаас 1 цагийн өмнө ирж, арга хэмжээ эхлэхээс 30 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.
- ✓ Нийт төгсөгчид хурлын танхимд сургалтын албанаас өгсөн өөрийн дугаарлалт бүхий суудалд суух бөгөөд гардуулах удирдлагуудын оноосон дугаарын дагуу эгнээ тус бүрээр дипломоо гардан авна.
- ✓ Нийт төгсөгчдөд хэсэг тус бүрийн тухайлсан хөтөлбөр, диплом гардаж авах нэрсийн жагсаалтын хамтаар хүргэнэ.
- ✓ Диплом энгэрийн тэмдэг гардуулах үеийн дурсгалын зургийг [Drive.google.com](https://drive.google.com) холбоосоор нээлттэй байршуулна.
- ✓ Төгсөгчид арга хэмжээ дууссаны дараа тухайлан засаж бэлтгэсэн газруудад дурсгалын зургууд татуулна. /1-р байрны үүдний хэсэг, 2-р байрны үүдний хэсэг болон бүрэлдэхүүн сургуулиудын тусгайлан засаж тохижуулсан хэсгүүд/

Эцэг, эхчүүдэд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн бэлтгэсэн зориулалтын талбайд дурсгалын зураг татуулж болно. /Хүснэгт 3-т заасан байрлалуудад/
- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн хүснэгт 4-т заасан байрлалууд болон ШУТИС-ийн пэйж хуудсаар шууд дамжуулалтыг хүлээн авна.
- ✓ Эцэг, эхчүүдийг арга хэмжээ зохион байгуулагдаж буй хурлын танхимд оруулахгүй болохыг анхаарна уу.
- ✓ ШУТИС-ийн 2-р байрны 1 давхарт байрлах 200 тоот буюу “ТВ заал”-нд, 1-р байр, 2-р байрны 1 давхарт байрлах дэлгэц болон гар утсаараа шууд дамжуулалтыг үзэх боломжтой.

Хавсралт-1



Хувцас солих өрөө

Хүснэгт .2

№	Сургуулийн нэр	Хичээлийн байр	Өрөөний дугаар, анги	Хариуцах эзэн
1	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	1-р байр	104 тоот	ГУУС, ОХСҮА
2	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	2- байр	421 тоот	ЭХС, ОХСҮА
3	Механик тээврийн сургууль	2-р байр	419 тоот	ЭХС, ОХСҮА
4	Бизнесийн ахисан түвшний сургууль	1-р байр	304 тоот	ГУУС, ОХСҮА
5	Барилга, архитектурын сургууль	Төгсөгчид сургалтын албанаас тодруулна.		
6	Гадаад хэлний сургууль			
7	Геологи, уул уурхайн сургууль			
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль			
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль			
10	Эрчим хүчний сургууль			

Шууд дамжуулалт

Хүснэгт.3

№	Байршил	Зураг	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хичээлийн 1-р байр хурлын танхимын үүдэнд байрлах дэлгэц		2024.01.19	ОХСҮА, НБТ
2	Хичээлийн 1-р байрны дэлгэц			

3	Хичээлийн 2-р байрны дэлгэц			
4	Хичээлийн 2-р байр 200 тоот тв заал			
5	ШУТИС-ийн пэйж хуудас	https://www.facebook.com/www.must.edu.mn		

Дурсгалын гэрэл зураг татуулах хэсэг

Хүснэгт.4

№	Байршил	Зураг	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хичээлийн 1-р байрны үүдний хэсэг			
2	Хичээлийн 2-р байрны үүдний хэсэг		2024.01.19	ОХСҮА, Бүрэлдэхүүн сургуулиуд
3	Бүрэлдэхүүн сургууль тус бүр тохиромжтой хэсгүүдэд дурсгалын зураг татуулах байрлалыг засч тохижуулсан хэсэг			

